



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГУРВАНСАЙХАН СУМЫН ЧУЛУУТ БАГИЙН ИРГЭДИЙН
НИЙТИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 08

Суугаант

Г

Г

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан
үнэлгээний тайланг дэмжих тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийн 8.4.8 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг тус тус үндэслэн багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Чулуут багийн нутаг дэвсгэрт байрших MV-021483 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Гурвансайхан сумын Чулуут багийн иргэдийн Нийтийн Хуралд танилцуулсныг хуралдаанд оролцсон багийн иргэд дэмжиж хүлээн авахаар шийдвэрлэсүгэй.

2. Багийн иргэдээс гаргасан саналыг тайлангийн холбогдох хэсэгт тусган оруулж, хамтран ажиллахыг байгаль орчны зөвлөх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэгч “Найчрал Састанэблэ” ХХК-д даалгасугай.

3. Тайланд дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн гүйцэтгэх захирал (С. Баярмөнх)-д үүрэг болгосугай.

ДАРГА д. СУГИР



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ЧУЛУУТ БАГИЙН ИРГЭДТЭЙ
УУЛЗАЖ САНАЛ ЗӨВЛӨМЖ АВСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр

№

Суугаант

Зорилго: Дундговь аймгийн Гурвансайхан сумын Чулуут багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8, 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалтын дагуу багийн иргэдэд танилцуулах.

Хаана: Дундговь аймгийн Гурвансайхан сумын Чулуут баг

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Чулуут багийн иргэдийн нийтийн хуралд БОННУ-ний тайлангийн талаар танилцуулга хийж санал хүсэлтийг сонсож иргэдийн саналыг давхардуулалгүйгээр багцлан тэмдэглэлээ.

Багийн иргэдийн нийтийн хуралд төслийн үйл ажиллагаа, тайлангийн үр дүнг танилцуулах ажилд Байгаль орчны зөвлөх, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний “Найчрал Састанайнэблэ” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн Д.Оюунжаргал нар оролцсон.

“Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн талаар бэлтгэсэн танилцуулгыг “Найчрал Састанайнэблэ” ХХК-ийн мэргэжилтэн Д.Оюунжаргал танилцуулж, төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулав.

“Найчрал Састанайнэблэ” ХХК-ийн мэргэжилтэн Д.Оюунжаргал “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн талаарх танилцуулга:

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын хүрээнд Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших Салхит нэртэй 2887.85 га талбай бүхий ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл /XV-2021416/-ийг “Эрдэнэс силвер ресурс” ХХК-д олгосон болно. Энэхүү шийдвэрийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас улсын төсвийн тогтвортой эх үүсвэрийг шинээр бий болгох, салбарын нөөц боломжийг зохицтойгоор ашиглах үүднээс Салхитын мөнгө-алтны ордын хайгуулын тусгай зөвшөөрөл /XV-021416/-ийн талбайд хууль тогтоомжийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдөр ашиглалтын тусгай зөвшөөрөл /MV-021483/-ийг авсан бөгөөд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааг боломжит богино хугацаанд цаг алдалгүй эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлтэйгээр ажиллаж байна. Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ашиглах ТЭЗҮ-г 2019 онд геологи, уул уурхайн зураг төслийн “Топази亞” ХХК боловсруулсан бөгөөд Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 074 дүгээр тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын орд ашиглалтын Техник-Эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) хүлээн авах журам дагуу нөөцийн тайлан тодотгол батлагдсан, геотехникийн судалгаа хийгдсэн, тоног төхөөрөмж өөрчлөгдсөн зэрэг үндэслэлээр уг ТЭЗҮ

(тодотгол-1)-ийг боловсруулж хүчин чадлыг 600 мян.тн/жил байхаар тооцоолсон байна. Тус батлагдсан ТЭЗҮ-д үндэслэн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг ажил гүйцэтгэх гэрээ, холбогдох хууль, дүрэм, аргачлал, заавар, журмын дагуу хийж гүйцэтгэв. Бид төслийн талбай дээрх хээрийн судалгааны ажлыг 2022 оны 6 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэн төслийн талбай, түүний орчны газруудад хөрс, усны дээж авах агаарын хэмжилт судалгаа хийх, дүйцүүлэн хамгаалалт хийгдэж буй “Их газрын чулууны БЦГ”-ын өнөөгийн нөхцөл байдалтай танилцаж нутгийн иргэдээс асуулга судалгааг авч ажиллалаа.

- Уг төслийг хэрэгжүүлснээр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон орчны иргэдийн хэвийн амьдрал, малын бэлчээр зэрэгт хэрхэн сөрөг нөлөөлөхийг тогтоож, түүний нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тодорхойлон төсөвт хөрөнгийг тооцон БОАЖЯамаар батлуулж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, түүгээр дамжуулан Монгол улсад хэрэгжиж буй хууль тогтоомж, стандартуудыг мөрдүүлэх зэрэг ажлуудыг танилцуулж байв.

Түүнчлэн дээрх төслийг хэрэгжүүлэхэд иргэд ямар ойлголттой байгааг асууж мэдээлэл өгөн, саналыг тодруулав.

“Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг танилцуулж хэлэлцэх үеэр иргэдээс төсөл хэрэгжүүлэгч болон үнэлгээний компанид дараах асуудлуудыг тавьсан. Үүнд:

- Гурван сайхан сумын Чулуут багийн иргэдэд төслийн талаар мэдээллийг цаашид үргэлжлүүлэн тогтвортой өгч байх
- Сумын иргэдийг ажлын байраар ханган ажиллуулах
- БОМТ хэрэгжүүлэн ажиллаж, тайлагнах
- Байгаль орчинд халгүй, сүүлийн үеийн дэвшилтэд технологи ашиглах
- Тээврийн замын асуудлыг шийдэх
- Малчдад тусламж дэмжлэг үзүүлэх
- Нөхөн сэргээлтийг цаг тухай бүрд нь хийх гэсэн саналууд гарсан юм.

Гурван сайхан сумын Чулуут багийн иргэд дараах асуултуудыг тавьж, зарим зүйлсийг тодруулж байв.

1. Иргэн Ц. Бүд: БОННҮ-ний тайлан нь төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бүрэн тодорхойлж чадсан уу?

“Найчрал Састанэблэ” ХХК-ийн мэргэжилтэн Д.Оюунжаргал: Манай компани тус төслийн БОННҮ-ний тайланг хийж гүйцэтгэхдээ чиглэл тус бүрт мэргэшсэн, туршлагатай шинжээч авч ажиллуулан тайланг боловсруулсан, тийм учраас төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг харьцангуй сайн тодорхойлж бууруулах арга хэмжээг төлөвлөсөн.

2. Иргэн Ц. Бүд: Олборлосон талбайгаа дор бүрт нь нөхөн сэргээгээд ажиллах юм уу? Олборлож дуусаад дараа нь нөхөн сэргээлтээ хийх юм уу?

“Найчрал Састанэблэ” ХХК-ийн мэргэжилтэн Д.Оюунжаргал: Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу нөхөн сэргээлтийг тухай бүрт нь хийж ажиллана.

“Эрдэнэс силвер ресурс” ХХК хариуцан хэрэгжүүлж буй “Салхитын ордын Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийг Канад улсын Гадаад хэргийн яамнаас санхүүжүүлж буй “Монгол улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төсөл, териийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлж байна.

Дээрх хэлэлцүүлгийн дараа дараах саналтайгаар хурлын хүрээнд хэлэлцүүлсэн төслийг дэмжицгээлээ. Үүнд:

- Бид байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний зорилго ач холбогдол байгаль хамгаалах үр өгөөжийг бүрэн ойлгож байна.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө бүрэн хангаж ажиллаж, нөхөн сэргээлтээ цаг тухай бүрд нь хийж гүйцэтгэх шаардлагатай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Тус багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэс silver ресурс” ХХК-ийн “Салхитын мөнгө-алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн Байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг багийн иргэд дэмжиж байгаа тул дэмжих нь зүйтэй гэж багийн ИНХ-аас шийдвэрлэж байна.

Иргэдийн саналыг давхардуулалгүй нэгтгэн тэмдэглэв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: *Оролмаа* Т. ОРОЛМАА

ТАНИЛЦСАН:

ХУРАЛДААНЫ ДАРГА *С. Сугир* Д. СУГИР

